

ГАЗРЫГ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ  
ХАМГААЛАЛТАД АВАХ ТУХАЙ

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны Ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.6 дах хэсэг, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дах заалт, Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.3, 20 дугаар зүйлийн 20.1.3 дах заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3, 20 дугаар зүйлийн 20.5, 28 дугаар зүйлийн 28.3, Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Шарын гол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын .... дахь удаагийн сонгуулийн ээлжит ... хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн заагийг Буянтын хөндийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн нийт 422.6 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсугай.

2. Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын зургийг нэгдүгээр хавсралтаар, булангийн цэгийн солбицлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт хамгаалалтын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг Засаг дарга (М.Мөнхбаяр)- д үүрэг болгосугай.

4. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эргэн тойронд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг орон нутгийн тусгай хамгаалалтад авсантай холбогдуулан бүсийн дэглэмийг мөрдөж ажиллахыг “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн захирал (П.Баярцэцэг)-т даалгасугай.

5. Газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан тухай шийдвэрийг Ашигт малтмал, газрын тосны газарт ажлын 10 хоногт багтаан хүргүүлж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу Хууль зүйн дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд ажлын 5 өдөрт багтаан бүртгүүлэхийг Иргэдийн хурлын нарийн бичгийн дарга (Б. Болорчимэг)-т даалгасугай.

ДАРГА

Б.БОЛАТ